

Хайчилбар

Хугацааны хязгаарлалт: 0.1 секунд

Санах ойн хязгаарлалт: 32 mb

Хүүхдүүд геометрийн хичээл дээр цаасаар хайчилбар дүрс бүтээн тоглож байна. Багш 3 цэг өгч тэдгээр цэгүүд орой нь болдог зөв олон өнцөгт хайчлах даалгавар өгчээ. Цаас бага тул аль болох хамгийн бага талбай хамрахаар зөв олон өнцөгтийг байгуулах шаардлага гарав. Тэдэнд туслаарай.

Оролт: Оролт 3 мөрөөс тогтох бөгөөд мөр бүрд оройн координатыг илтгэх хос бодит тоо өгөгдөнө. Аль ч координат абсолют утгаараа 1000-аас хэтрэхгүй бөгөөд таслалын ард хамгийн ихдээ 6 орон өгөгдөнө.

Гаралт: Хамгийн бага боломжит талбайг гаргана. Хариу хамгийн багадаа таслалын ард 6 оронгийн нарийвчлалтай байх ёстой. Зөв олон өнцөгтийн оройн тоо 100-аас хэтрэхгүй гэж үзэж болно. Алдаа 10^{-4} -аас бага бол зөв хариулт гэж үзнэ.

Жишээ

Оролт	Гаралт
0.000000 0.000000	1.00000000
1.000000 1.000000	
0.000000 1.000000	